



Өөрчлөлтийг манлайлах нь ЦУНБХТ

Техникийн зөвлөх: Чак Конлон

2019 оны 11-р сар

Өөрчлөлтийг манлайлах нь

Зорилт:

- Бүх удирдах албан хаагчдын өөрчлөлтийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх
- Удирдах албан хаагчдад өөрчлөлтийг удирдах загварын танилцуулах
- Өөрчлөлтийн үйл явцийн чухал бүрдэл хэсгүүдийн талаарх ойлголт бэхжүүлэх
- Удирдах албан хаагчдад өөрчлөлтийн үйл явцтай танилцуулах, түүнийг хөшүүрэг болгон ашиглах дасгал ажил ажиллуулах

ЦУНБХТ-ийн эрхэм зорилго

- Монголын ард түмэн, олон улсын хамтын ажиллагаанд тулгуурлан Монгол орны байгалийн нөөц баялагийг зөв зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Өнөөгийн өөрчлөлт юунаас үүдэлтэй вэ?

- Орчны маш хурдтай хувьсан өөрчлөлт
- Даяарчлал ба дэлхий дахины ширүүн өрсөлдөөн
- Шинэ технологи ба мэдээллийн урсгал
- Хүн амын насжилт, хүн ам зүйн шилжилт
- Иргэд мэдээлэл сайтай болж, оролцоо нь нэмэгдэхийн хэрээр тавих шаардлага нь өндөрссөн
- Мэргэжилтнүүд, улс төрчид болон байгууллагуудад итгэх итгэл буурсан
- Төрийн албаны засаглал, хариуцлага, төрийн албаны инновацид илүү анхаарах болсон

Өөр ямар хүчин зүйлийн улмаас танай Төвд өөрчлөлт өрнөж байна вэ?

Дасгал ажил 1



ЦУНБХТ-д чухал ахиц дэвшил авчирсан нэг өөрчлөлтийн талаар ярилцана уу.

Тэрхүү өөрчлөлт яагаад амжилттай явагдсан бэ?

Өөрчлөлтийн муруй

Өөрчлөлтөд үзүүлэх сэтгэл санааны хариу үйлдэл



Бүтээлчээр зохицох

Харилцаа холбоогоо сайжруулах

Сэдэл төрөх

Чадамж суулгах

Мэдлэг түгээх

Хариу үйлдэл

Өсөлтийн сэтгэлгээ

Даван туулах

Дасгал ажил 2

ЦУНБХТ-ын удирдлагын баг 2016 онд өөрчлөгдсөнөөр илүү мэргэжлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн.

Уг шинэ удирдлагын багийн хийсэн 2-3 гол өөрчлөлт юу байсан бэ?

Энэ өөрчлөлтийн тухайд дараах зүйлсийг ярилцацгаая.

- Тухайн өөрчлөлтийн хувьд албан хаагчдын санааг зовоож байсан гол зүйлс юу байсныг тодорхойлно уу.
- Эдгээр санаа зовнилыг шийдвэрлэж, өөрчлөлтийг амжилттай өрнүүлэхэд шинэ удирдлагуудын хувьд ямар арга хэмжээ авсан бэ?

“ADKAR” загвар: Өөрчлөлт нь нарийн төвөгтэй, бэрхшээлтэй үйл явц юм

- “ADKAR” бол англи хэлний ойлгож мэдэх (awareness), хүсэл тэмүүлэл (desire), мэдлэг (knowledge), чадвар (ability) ба бататгах (reinforcement) зэрэг үгсийн товчлол юм.
- Хувь хүний түвшинд өөрчлөлтийн явцыг ойлгон удирдаж, амжилтад хүрэх нөхцөл бүрдүүлж, бодитой болгох тогтолцоо юм.



Яагаад загвар? Яагаад “ADKAR” загвар гэж?

- Албан хаагчид өөрчлөлтийг хэр эсэргүүцэж байгааг илрүүлэх
- Албан хаагчид өөрчлөлтийн үйл явцыг даван туулж шилжилт хийхэд нь туслах
- Өөрчлөлт хийх санаачилгын үеэр албан хаагчдыг хувь хүний болон мэргэжлийн түвшинд хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө амжилттай боловсруулах
- Албан хаагчидад зориулан өөрчлөлтийн менежментийн төлөвлөгөө боловсруулах
- Тависан гол зорилтуудад хүрэх магадлалыг нэмэгдүүлэх

Өөрчлөлт хийх шаардлагын талаарх ойлгож мэдэх Дасгал ажил 3

Дасгал ажил 2 дээр тодорхойлсон өөрчлөлтийн талаар бодоцгооё.


- Энэхүү өөрчлөлтийг хийх хэрэгцээ шаардлагыг бий болгосон ямар гадаад, дотоод хүчин зүйлс байсан бэ?
- Албан хаагчдад энэ талаар мэдээлэл өгөхдөө хэлсэн, эсвэл хэлбэл зохих байсан хамгийн чухал 2 зүйлс юу байсан бэ?

Өөрчлөлтийг дэмжих хувь хүний шийдвэр буюу хүсэл тэмүүлэл төрөх Дасгал ажил 4

- Өөрчлөлтийг хийхэд албан хаагчдын дэмжлэгийг авахын тулд юуг анхаарч үзсэн бэ? Санамж: Өөрчлөлт бол хувь хүний сонголт.
- Албан хаагчдыг ятган ойлгуулахад удирдлагын хувьд ашигласан буюу ашиглаж болох байсан 3 зүйлийг тодорхойлно уу.
- Эдгээр өөрчлөлтөд дэмжлэг авахын тулд багийнхныхаа хэнд нь хандсан вэ? Өөрчлөлтийг эрт үед нь дэмжиж нэвтрүүлсэн албан хаагчид байсан уу?
- Тухайн өөрчлөлтийг хийхэд үүрэг хүлээж, хичээл зүтгэл гаргаж буйгаа хэрхэн харуулсан бэ?

Мэдлэг, чадвар эзэмших Дасгал ажил 5

- Албан хаагчдад эдгээр өөрчлөлтийн аль нэгийг нь хийхэд шаардлагатай мэдлэг, чадвар байгааг тодорхойлох 2 аргыг нэрлэнэ үү.



Өөрчлөлт бол:

- Судалгаанд суурилагдана
- Тасралтгүй явагдана
- Удирдлагын хүлээх хариуцлагын нэг
- Өсөн дэвшихэд зайлшгүй шаардлагатай
- Олон улсын хэмжээнд хамтын ажиллагааг бэхжүүлж, үр бүтээлтэй ажиллах хүчирхэг байгууллага болоход чухал үүрэг гүйцэтгэнэ



Ирээдүйг хамтын хичээл зүтгэлээр бүтээдэг. Та ирээдүйн талаар ганцаараа шийдэж чадахгүй, тэр дундаа ганцаараа бүтээж бүр ч чадахгүй.

Удирдах албан хаагчийн хувьд бид өөрчлөлтийг манлайлан удирдаж, ЦУНБХТ-ийг дэлхийн жишигт хүрсэн байгууллага болгоно



Баярлалаа!

Асуулт, хариулт